



ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АЛБА

2022 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ

Хянасан:

Б.Түмэн-Өлзий /СТСАлбаны дарга,
Мэдээлэл зүйн мэргэжилтэн/

Тайлан боловсруулсан:

СТСАлбаны:

А.Жаргалмаа /Эпидемиологич/

Б.Баянзул /НЭМ-ийн мэргэжилтэн/

Х.Мөнхзул /Эпидемиологич/

ГАРЧИГ

- Товчилсон үгийн жагсаалт
- Үзүүлэлт тооцох аргачлал

БҮЛЭГ 1

- 2022 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 2

- 2022 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
- Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---------|--|
| ГССҮТ | Гэмтэл согог судлалын үндэсний төв |
| СТСА | Статистик тандалт судалгааны алба |
| ЭМХТ | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| НЭМГ | Нийслэлийн эрүүл мэндийн газар |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЭХЭМҮТ | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв |
| УНТЭ | Улсын нэгдүгээр төв эмнэлэг |
| УХТЭ | Улсын хоёрдугаар төв эмнэлэг |
| УГТЭ | Улсын гуравдугаар төв эмнэлэг |
| СЭМҮТ | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв |
| ШШҮХ | Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн |
| МЯСЭ | Монгол-Японы сургалтын эмнэлэг |
| ЦТЭ | Цэргийн төв эмнэлэг |
| ТЗНЭ | Төмөр замын нэгдсэн эмнэлэг |
| ТТАХНЭ | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг |
| ХАЯТТ | Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг |
| БОЭТ | Бүсийн оношилгоо эмчилгээний төв |
| БГДЭМТ | Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв |
| БЗДНЭМТ | Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв |
| СХДНЭМТ | Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв |
| СБДНЭМТ | Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв |
| ХУДЭМТ | Хан уул дүүргийн эрүүл мэндийн төв |
| ЧДЭМТ | Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв |
| НДЭМТ | Налайх дүүргийн эрүүл мэндийн төв |
| БндЭМТ | Багануур дүүргийн эрүүл мэндийн төв |
| БхдЭМТ | Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв |

ҮЗҮҮЛЭЛТ ТООЦСОН АРГАЧЛАЛ

1. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдлын түвшинг (ТТ) тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
2. Осол гэмтлийн тархалтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
3. Осол гэмтлийн шалтгаан тус бүрийн өвчлөлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн (ӨОУА-10 дагуу осол гэмтлийн шалтгаан тус бүрээр) осол гэмтлийн шинэ өвчлөлийн тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
4. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
5. Осол гэмтлийн үхлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн тоонд харьцуулан, 1 000 гэмтэл тутамд тооцсон.
6. Осол гэмтлийн шалтгаан бүрт нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн нас баралтыг тухайн жилийн дундаж хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
7. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын болон өвчлөлийн тархалтыг харуулахдаа тухайн аймаг, дүүрэгт бүртгэгдсэн тохиолдлыг тухайн аймаг дүүргийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.




I БҮЛЭГ

**2022 оны осол гэмтлийн шалтгаант
өвчлөлийн байдалд хийсэн дүн
шинжилгээ**


МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ 2022

1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

2022 онд Монгол улсын хэмжээнд осол гэмтлийн шалтгаант 188 916 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс өссөн ба өнгөрөгч оноос 32.6%-иар, 2019 оноос 20.5%-иар тус тус өссөн байна. Харин Ковид 19 цар тахлын өвчлөл, хөл хорионы үед буюу 2020 болон 2021 онд осол гэмтлийн өвчлөл буурсан үзүүлэлттэй байна.




Нийт тохиолдлын 60.1%-ийг эрэгтэйчүүд, 39.9%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутамд 6 эрэгтэй, 4 эмэгтэй ногдож буй үзүүлэлт хэвээр байна.




Осол гэмтэлд өртсөн дундаж нас 27.7 стандарт хазайлт ± 19.4 байгаа бол хамгийн багадаа 0 сартайгаас 101 нас хүртэлх хүмүүс хамаарч байна.

| Variable | Case | Mean | Std. Dev. | Min | Max |
|----------|---------|------|-----------|-----|-----|
| Нас | 188 916 | 27.7 | 19.4 | 0 | 101 |


Тохиолдлын тоогоор 0-4 насныхан хамгийн их байгаа бол тухайн насны 10 000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 15-19 насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад өндөр байна.




Насны бүлэг хүйсээр авч үзвэл эмэгтэйд 0-4 насанд, эрэгтэйд 10-14 насанд тохиолдол их байна.



2022 онд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 36.5% гэртээ, 31.0% гудамж, зам дээр, 8.5% биеийн тамир спортын талбайд тус тус гэмтсэн байгаа бол хамгийн бага хувийг олон нийтийн газар гэмтсэн тохиолдол эзэлсэн байна.



Нийт бүртгэгдсэн тохиолдлын 86.7%-ийг санамсаргүй осол, 9.9%-ийг санаатайгаар үйлдэгдсэн осол эзэлсэн байна. Амиа хорлохыг завдах /ӨОУА-санаатайгаар өөртөө гэмтэл учруулах/ болон хүчирхийллийн /ӨОУА-дайралт, халдлага/ шалтгаанууд нь санаатайгаар үйлдэгддэг осол гэмтэлд багтдаг. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн 10 шинэ тохиолдлын 1 нь өөрийгөө болон бусдыг санаатайгаар гэмтээсэн болон өөртөө хохирол учруулсан тохиолдлууд байна. Харин 3.4%-д шалтгааны сэдэл тодорхойгүй байна.




Өнгөрсөн онд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 8.0% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн байна. Санамсаргүй хордох хорт бодист өртөх, амиа хорлохыг завдах, байгалийн хүчинд өртөх шалтгааны үед согтууруулах ундаа хэрэглэсэн хувь өндөр байна.

Хүснэгт 1. Осол гэмтлийн шалтгаан, согтууруулах ундаа хэрэглэсэн хувь

| Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх | Тээврийн хэрэгслийн төрөл | | | | | | | | | | | | | |
|---|---------------------------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|
| | V01-V99 | W00-W19 | W20-W49 | W50-W64 | W65-W74 | W75-W84 | W85-X19 | X20-X29 | X30-X39 | X40-X49 | X50-X59 | X60-X84 | X85-Y09 | Y10-Y34 |
| | Хувиар | | | | | | | | | | | | | |
| Хэрэглэсэн N=15121 (8.0%) | 7.8 | 2.7 | 3.1 | 2.2 | 19.6 | 12.7 | 1.9 | 0.9 | 35.9 | 58.4 | 0.5 | 50.8 | 37.0 | 7.5 |
| Хэрэглээгүй N=173795 (92.0%) | 92.2 | 97.3 | 96.9 | 97.8 | 80.4 | 87.3 | 98.1 | 99.1 | 64.1 | 41.6 | 99.5 | 49.2 | 63.0 | 92.5 |



Гэмтлийн байршлийг толгойн гэмтэл 23.0%-иар тэргүүлж мөн тохой шуу, шагай ба тавхай, бугуй сарвуу, өвдөг шилбэндээ гэмтэх авах тохиолдлууд зонхилсон байна.




Тэргүүлэх шалтгаан тус бүрийг гэмтлийн байршлаар авч үзвэл хүчирхийлэл болон зам тээврийн ослын үед толгойн гэмтэл, уналтын шалтгааны үед шагай тавхайн гэмтэл, амьтай механик хүчинд өртөх гэмтлийн үед тохой ба шууны гэмтэл, амьгүй механик хүчинд өртөх гэмтлийн үед бугуй сарвууны гэмтэл зонхилон тохиолдож байгаа буюу гэмтсэн эрхтний байршил шалтгаанаас хамааран харилцан ялгаатай байна.

Хүснэгт 2. Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан оношийн матриц

| Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан | Гэмтлийн байршил | | | | |
|----------------------------------|--------------------------------|------------------------------------|--------------------------------------|---------------------------------------|--------------------------------------|
| | I | II | III | IV | V |
| W00-W19 Уналт | Шагай ба тавхайн гэмтэл 20.8% | Тохой ба шууны гэмтэл 18.0% | Тархины гэмтэл 16.7% | Өвдөг ба шилбэний гэмтэл 13.6% | Бугуй ба сарвууны гэмтэл 7.0% |
| W20-W49 Амьгүй механик | Бугуй ба сарвууны гэмтэл 42.9% | Тархины гэмтэл 19.1% | Шагай ба тавхайн гэмтэл 10.1% | Тохой ба шууны гэмтэл 9.5% | Өвдөг ба шилбэний гэмтэл 5.6% |
| V01-V99 Зам тээврийн осол | Тархины гэмтэл 38.8% | Өвдөг ба шилбэний гэмтэл 10.8% | Цээжний гэмтэл 9.3% | Хэвлийн гэмтэл 8.6% | Мөр ба бугалгын гэмтэл 7.0% |
| X85-Y09 Хүчирхийлэл | Тархины гэмтэл 67.2% | Цээжний гэмтэл 9.1% | Бугуй ба сарвууны гэмтэл 5.2% | Хэвлийн гэмтэл 4.4% | Тохой ба шууны гэмтэл 4.3% |
| W50-W64 Амьтай механик | Тохой ба шууны гэмтэл 29.8% | Тархины гэмтэл 16.3% | Бугуй ба сарвууны гэмтэл 13.7% | Өвдөг ба шилбэний гэмтэл 12.1% | Түнх ба гуяны гэмтэл 6.2% |
| Нийт дүнгээр тэргүүлэх байршил | Тархины гэмтэл 23.0% | Тохой ба шууны гэмтэл 14.0% | Шагай ба тавхайн гэмтэл 12.7% | Бугуй ба сарвууны гэмтэл 12.3% | Өвдөг ба шилбэний гэмтэл 9.9% |

Осол гэмтэлд өртсөн хүмүүсийн ихэнх хувь нь зөөлөн эд гэмтсэн, шарх болон хугарлын оношоор тусламж үйлчилгээ авсан байна.



Уналт болон хүчирхийлэл өвлийн улиралд, амьгүй механик хүчинд өртөх, зам тээврийн осол, амьтай механик хүчинд өртөх шалтгаан зуны улиралд илүүтэй тохиолддог байна.

Хүснэгт 3. Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан улирлын матриц

| Шалтгаан \ Улирал | Уналт | Амьгүй механик хүчинд өртөх | Зам тээврийн осол | Хүчирхийлэл | Амьтай механик хүчинд өртөх |
|-------------------|-------|-----------------------------|-------------------|-------------|-----------------------------|
| Өвөл | 47.3% | 13.6% | 8.7% | 10.5% | 7.0% |
| Хавар | 45.5% | 16.2% | 10.7% | 9.0% | 8.4% |
| Зун | 42.1% | 17.3% | 14.2% | 7.9% | 9.0% |
| Намар | 45.0% | 16.6% | 10.3% | 9.5% | 7.9% |

Насны бүлэг тус бүрээр осол гэмтлийн шалтгааныг авч үзвэл бүх насанд уналтын шалтгаан тэргүүлж, 0-4 насанд түлэгдэлт 3-рт орж бусад насанд амьгүй механик хүчинд өртөх болон зам тээврийн осол 2-р шалтгаан болсон байна. Дараах хүснэгтээс дэлгэрүүлж харна уу.

Хүснэгт 4. Осол гэмтлийн шалтгаан, насны бүлэг, хувиар


| Насны бүлэг | Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан | | | | |
|-------------|------------------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|---------------------------|
| | I | II | III | IV | V |
| 0-4 | Уналт 46.0% | Амьд м/х-д өртөх 16.1% | Түлэгдэлт 13.9% | Амьгүй м/х-д өртөх 11.7% | Шалтгаан тодорхойгүй 7.2% |
| 5-9 | Уналт 53.2% | Амьгүй м/х-д өртөх 14.8% | Амьд м/х-д өртөх 11.6% | Зам тээврийн осол 10.6% | Шалтгаан тодорхойгүй 4.2% |
| 10-14 | Уналт 54.0% | Амьгүй м/х-д өртөх 14.6% | Амьд м/х-д өртөх 11.2% | Зам тээврийн осол 11.1% | Хүчирхийлэл 4.6% |
| 15-19 | Уналт 47.0% | Амьгүй м/х-д өртөх 17.8% | Зам тээврийн осол 11.9% | Амьд м/х-д өртөх 9.0% | Хүчирхийлэл 8.2% |
| 20-24 | Уналт 35.9% | Амьгүй м/х-д өртөх 21.3% | Хүчирхийлэл 15.0% | Зам тээврийн осол 13.6% | Амьд м/х-д өртөх 6.6% |
| 25-29 | Уналт 35.5% | Амьгүй м/х-д өртөх 19.3% | Хүчирхийлэл 17.2% | Зам тээврийн осол 13.0% | Амьд м/х-д өртөх 6.2% |
| 30-34 | Уналт 35.4% | Амьгүй м/х-д өртөх 19.6% | Хүчирхийлэл 17.1% | Зам тээврийн осол 12.5% | Амьд м/х-д өртөх 5.5% |
| 35-39 | Уналт 36.5% | Амьгүй м/х-д өртөх 19.5% | Хүчирхийлэл 15.8% | Зам тээврийн осол 12.9% | Амьд м/х-д өртөх 4.9% |
| 40-44 | Уналт 37.6% | Амьгүй м/х-д өртөх 18.1% | Хүчирхийлэл 14.3% | Зам тээврийн осол 13.6% | Амьд м/х-д өртөх 4.5% |
| 45-49 | Уналт 40.5% | Амьгүй м/х-д өртөх 16.9% | Зам тээврийн осол 13.6% | Хүчирхийлэл 11.9% | Амьд м/х-д өртөх 4.9% |
| 50-54 | Уналт 45.4% | Амьгүй м/х-д өртөх 13.9% | Зам тээврийн осол 13.7% | Хүчирхийлэл 9.4% | Амьд м/х-д өртөх 5.3% |
| 55-59 | Уналт 51.2% | Зам тээврийн осол 12.8% | Амьгүй м/х-д өртөх 12.6% | Хүчирхийлэл 6.7% | Амьд м/х-д өртөх 5.4% |
| 60-64 | Уналт 54.5% | Зам тээврийн осол 11.8% | Амьгүй м/х-д өртөх 11.6% | Амьд м/х-д өртөх 5.8% | Хүчирхийлэл 5.2% |
| 65-69 | Уналт 63.5% | Зам тээврийн осол 10.3% | Амьгүй м/х-д өртөх 8.5% | Амьд м/х-д өртөх 5.0% | Шалтгаан тодорхойгүй 3.3% |
| 70+ | Уналт 74.1% | Зам тээврийн осол 6.6% | Амьгүй м/х-д өртөх 5.6% | Амьд м/х-д өртөх 3.8% | Шалтгаан тодорхойгүй 3.5% |

2022 онд осол гэмтэл зуны улиралд, 5, 6, 7 саруудад болон ням, даваа гарагт хамгийн их бүртгэгдсэн байна.

Осол гэмтэл бүртгэгдсэн гараг




Осол гэмтэл бүртгэгдсэн сар



Нийт тохиолдлын 82.2% нь нийслэлд, 17.8% нь орон нутагт бүртгэгдсэн байгаа ба тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин нийслэлд 751.8, орон нутагт 138.8 байна.

Осол гэмтлийн шинэ тохиолдол, бүртгэгдсэн газраар




Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл Архангай, Булган, Говь-Алтай, Дундговь Завхан, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгуудад тэргүүлэх шалтгаан болсон байгаа бол бусад аймгуудад уналтын шалтгаан тэргүүлжээ. Харин Өмнөговь аймагт амьгүй механик хүчинд өртөх гэмтэл их бүртгэгдсэн байна.

Хүснэгт 5. Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан, аймгаар

| Аймгийн нэр | | Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан | | | | |
|-------------|--------|------------------------------------|------------------------|------------------------|------------------------|-----------------------|
| | | I | II | III | IV | V |
| Архангай | 2535 | ЗТО 28.0% | Уналт 21.7% | Амьгүй м/х өртөх 16.5% | Хүчирхийлэл 14.0% | Амьтай м/х өртөх 8.6% |
| Баян-Өлгий | 776 | Уналт 59.0% | ЗТО 14.8% | Хүчирхийлэл 8.1% | Амьгүй м/х өртөх 6.8% | Түлэгдэлт 5.9% |
| Баянхонгор | 1184 | Уналт 42.0% | ЗТО 23.9% | Хүчирхийлэл 9.5% | Амьгүй м/х өртөх 7.7% | Түлэгдэлт 5.4% |
| Булган | 842 | ЗТО 30.2% | Уналт 29.8% | Амьгүй м/х өртөх 15.6% | Хүчирхийлэл 11.1% | Амьтай м/х өртөх 5.0% |
| Говь-Алтай | 1001 | ЗТО 27.7% | Уналт 24.4% | Амьгүй м/х өртөх 18.3% | Хүчирхийлэл 12.4% | Амьтай м/х өртөх 7.6% |
| Дорноговь | 3256 | Уналт 41.9% | Амьгүй м/х өртөх 19.3% | ЗТО 15.0% | Хүчирхийлэл 11.6% | Хордолт 3.9% |
| Дорнод | 1260 | Уналт 36.8% | ЗТО 21.2% | Амьгүй м/х өртөх 14.8% | Хүчирхийлэл 11.9% | Түлэгдэлт 6.2% |
| Дундговь | 591 | ЗТО 38.6% | Уналт 20.1% | Хүчирхийлэл 15.6% | Амьгүй м/х өртөх 9.5% | Амьтай м/х өртөх 8.1% |
| Завхан | 1421 | ЗТО 29.1% | Уналт 20.7% | Амьгүй м/х өртөх 18.4% | Хүчирхийлэл 14.3% | Амьтай м/х өртөх 7.5% |
| Өвөрхангай | 1352 | Уналт 30.3% | Амьгүй м/х өртөх 24.2% | ЗТО 23.7% | Хүчирхийлэл 7.8% | Амьтай м/х өртөх 5.9% |
| Өмнөговь | 1225 | Амьгүй м/х өртөх 27.5% | ЗТО 25.1% | Уналт 17.9% | Хүчирхийлэл 13.0% | Түлэгдэлт 6.1% |
| Сүхбаатар | 793 | ЗТО 37.8% | Уналт 26.7% | Хүчирхийлэл 9.5% | Амьгүй м/х өртөх 8.3% | Түлэгдэлт 7.3% |
| Сэлэнгэ | 1225 | Уналт 22.8% | Хүчирхийлэл 19.9% | ЗТО 19.5% | Амьгүй м/х өртөх 18.0% | Амьтай м/х өртөх 6.9% |
| Төв | 1941 | Уналт 31.3% | ЗТО 25.4% | Амьгүй м/х өртөх 14.8% | Хүчирхийлэл 11.4% | Амьтай м/х өртөх 5.0% |
| Увс | 903 | ЗТО 27.1% | Уналт 26.1% | Амьгүй м/х өртөх 16.4% | Хүчирхийлэл 9.1% | Түлэгдэлт 7.6% |
| Ховд | 723 | Уналт 53.1% | ЗТО 19.9% | Амьгүй м/х өртөх 13.0% | Түлэгдэлт 4.8% | Хүчирхийлэл 3.5% |
| Хөвсгөл | 1826 | ЗТО 27.4% | Уналт 24.3% | Амьгүй м/х өртөх 16.6% | Хүчирхийлэл 13.5% | Амьтай м/х өртөх 4.8% |
| Хэнтий | 1439 | Уналт 24.0% | ЗТО 21.3% | Амьгүй м/х өртөх 19.1% | Хүчирхийлэл 15.4% | Амьтай м/х өртөх 7.9% |
| Дархан-Уул | 2040 | Уналт 32.1% | Хүчирхийлэл 22.6% | Амьгүй м/х өртөх 17.9% | ЗТО 11.7% | Хордолт 3.9% |
| Орхон | 895 | Уналт 40.5% | ЗТО 20.3% | Амьгүй м/х өртөх 13.1% | Хүчирхийлэл 7.7% | Хордолт 4.9% |
| Говьсүмбэр | 560 | Уналт 31.1% | Амьгүй м/х өртөх 21.6% | ЗТО 15.5% | Хүчирхийлэл 14.5% | Амьтай м/х өртөх 7.7% |
| Улаанбаатар | 161128 | Уналт 47.2% | Амьгүй м/х өртөх 16.0% | ЗТО 9.1% | Хүчирхийлэл 8.5% | Амьтай м/х өртөх 8.7% |


2022 онд осол гэмтлийн шинэ тохиолдол Дорноговь аймагт болон Төвийн бүсэд хамгийн их байсан байна.

Осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн харьяаллаар




1.1 УНАЛТЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /W00-W19/

Унаж гэмтэх нь жил бүрийн осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан болдог. Өөрөөр хэлбэл 2022 оны осол гэмтлийн өвчлөлийн 44.8% нь уналтын шалтгаантай байсан ба өмнөх онтой харьцуулахад 41.4%-иар өссөн байна.



2022 оны унаж гэмтсэн шалтгааны 53.7% нь эрэгтэй, 46.3% нь эмэгтэй байгаа ба тохиолдлын тоогоор 10-14 насанд хамгийн их ба эрэгтэйд нас ахих тусам буурсан зүй тогтолтой байна.





Унаж гэмтсэний улмаас тусламж үйлчилгээ авсан нийт үйлчлүүлэгчдийн гэмтлийн оношийг 20.8%-иар шагай тавхайн гэмтэл тэргүүлсэн байна. Мөн унасан тохиолдолд тохой шуу, толгой, өвдөг шилбэ, бугуй сарвуу, мөр бугалга илүүтэй гэмтдэг байна. Тэгвэл гэмтлийн төрлийн 46.1%-ийг зөөлөн эдийн гэмтэл эзэлсэн ба аль нэг эрхтний хугарал, шарх, мултрал суналт болон гавал доторх гэмтлүүд зонхилон тохиолддог байна.

Хүснэгт 1. Уналтын шалтгаант өвчлөл ӨОУА-10, оношийн бүлгээр


| Гэмтлийн байршил | 2022 | | Гэмтлийн төрөл | 2022 | |
|---|-----------|------|-------------------------|-----------|------|
| | Бодит тоо | Хувь | | Бодит тоо | Хувь |
| Шагай ба тавхайн гэмтэл /S90-S99/ | 17602 | 20.8 | Зөөлөн эдийн гэмтэл | 39231 | 46.4 |
| Тохой ба шууны гэмтэл /S50-S59/ | 15199 | 18.0 | Хугарал | 22840 | 27.0 |
| Толгойн гэмтэл /S00-S09/ | 14150 | 16.7 | Шарх | 7217 | 8.5 |
| Өвдөг ба шилбэний гэмтэл /S80-S89/ | 11538 | 13.6 | Мултрал, суналт | 7595 | 9.0 |
| Бугуй ба сарвууны гэмтэл /S60-S69/ | 5881 | 7.0 | Гавал доторхи гэмтэл | 6116 | 7.2 |
| Мөр ба бугалгын гэмтэл /S40-S49/ | 5600 | 6.6 | Бусад тодорхойгүй | 569 | 0.7 |
| Хэвлийн гэмтэл /S30-S39/ | 5314 | 6.3 | Шөрмөсний гэмтэл | 551 | 0.7 |
| Цээжний гэмтэл /S20-S29/ | 4913 | 5.8 | Хэвлийн хөндийн гэмтэл | 152 | 0.2 |
| Түнх ба гуя орчмын гэмтэл /S70-S79/ | 3385 | 4.0 | Мэдрэлийн гэмтэл | 115 | 0.1 |
| Хүзүүний гэмтэл /S10-S19/ | 527 | 0.6 | Цээж доторхи гэмтэл | 95 | 0.1 |
| Бусад гэмтэл /T10-T19//T36-T198/ | 275 | 0.3 | Судасны гэмтэл | 30 | 0.0 |
| Биеийн олон хэсэг хамарсан гэмтэл /T00-T09/ | 218 | 0.3 | Аарцгийн хөндийн гэмтэл | 26 | 0.0 |
| | | | Эд эрхтэн тайрагдах | 23 | 0.0 |
| | | | Хүндрэл | 23 | 0.0 |
| | | | Эд эрхтэн бяцрах | 19 | 0.0 |

Уналт дундаа хамгийн түгээмэл тохиолддог нэг түвшин дээр халтирч тээглэж, бүдэрч унах шалтгаан нь бүх насны бүлэгт тэргүүрж байгаа бол 0-9 болон 70+ насанд орноос унах тохиолдол цөөнгүй байдаг байна. Сүүлийн жилүүдэд цана чарганаас унаж гэмтэх тохиолдол бүртгэгдэх нь нэмэгдэж байгаа ба энэ нь 5-9 насны хүүхдүүдийн тэргүүлэх шалтгааны 5-д багтсан байна.


Хүснэгт 2.3. Уналт тэргүүлэх шалтгаан, насны бүлгийн матриц

| Насны бүлэг | Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан | | | | |
|-------------|--|--|---|---|---|
| | I | II | III | IV | V |
| 0-4 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 48.6% | Орноос ойчих 23.4% | Сандлаас унах 5.4% | Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 4.4% | Шат гишгүүрээс ойчих 3.5% |
| 5-9 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 48.4% | Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 14.9% | Шат гишгүүрээс ойчих 7.6% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.6% | Тэшүүр, цана, чарганаас ойчих 5.0% |
| 10-14 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 57.3% | Шат гишгүүрээс ойчих 9.8% | Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 8.9% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 6.3% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 5.8% |
| 15-19 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 62.2% | Шат гишгүүрээс ойчих 9.8% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 6.8% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.6% | Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 4.4% |
| 20-24 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 56.9% | Шат гишгүүрээс ойчих 14.6% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 8.2% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 5.5% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.8% |
| 25-29 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 57.0% | Шат гишгүүрээс ойчих 15.2% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 8.7% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.2% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 4.7% |
| 30-34 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 54.2% | Шат гишгүүрээс ойчих 16.3% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 9.7% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.1% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 4.4% |
| 35-39 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 54.3% | Шат гишгүүрээс ойчих 16.4% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 10.1% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.0% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 2.7% |
| 40-44 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.9% | Шат гишгүүрээс ойчих 18.7% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 10.5% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.9% | Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 2.7% |
| 45-49 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 54.2% | Шат гишгүүрээс ойчих 16.6% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 12.4% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.3% | Барилга, байгууламжаас ойчих 1.8% |
| 50-54 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 55.1% | Шат гишгүүрээс ойчих 15.9% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 13.4% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.9% | Сандлаас унах 2.6% |
| 55-59 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 57.6% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 15.0% | Шат гишгүүрээс ойчих 14.4% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.5% | Сандлаас унах 2.8% |
| 60-64 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 60.2% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 13.6% | Шат гишгүүрээс ойчих 13.3% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 3.9% | Сандлаас унах 3.2% |
| 65-69 | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 65.4% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 12.3% | Шат гишгүүрээс ойчих 12.1% | Сандлаас унах 3.1% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 2.3% |
| 70+ | Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 68.9% | Шат гишгүүрээс ойчих 9.8% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 7.5% | Орноос ойчих 4.8% | Сандлаас унах 4.3% |


2022 оны уналтын шалтгаант шинэ тохиолдлын 36.9% нь гэртээ болон гэрийнхээ ойролцоо 28.5% нь гудамж зам талбайд гэмтсэн байгаа бол 13.1% нь биеийн тамир спортын талбайд гэмтсэн байна. Мөн сургууль цэцэрлэг дээр унасан тохиолдол багагүй хувийг эзэлжээ.




Унаж гэмтэх нь ихэвчлэн зуны улиралд хамгийн их бүртгэгддэг бол 2022 онд хавар бусад улиралтай харьцуулахад их байжээ.




Уналт өвлийн саруудад хамгийн бага 5 болон 6 саруудад хамгийн их байна.



Гарагаар авч үзвэл даваа гарагт бусад өдрүүдтэй харьцуулахад тохиолдол өндөр байсан байна.



2022 оны уналтын шалтгаант шинэ тохиолдлын 89.9% нь нийслэлд, 10.1% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл нийслэлд орон нутгаас 9 дахин их байна.




Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах шалтгаан нийслэл, орон нутагт аль алинд нь 50 гаруй хувийг эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна. Шатнаас унаж гэмтэх тохиолдол 11 орчим хувийг эзэлж уналт дотроо тэргүүлэх 2-р шалтгаан болж байгаа бол удаах шалтгаануудын хувьд нийслэл, орон нутгаар ялгаатай байна.

Хүснэгт 2.7. Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, харьяаллаар

| Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан | № | Орон нутаг | Нийслэл | Улсын дүнгээр |
|--|---|---|---|---|
| | 1 | Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 59.3% | Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 55.1% | Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 55.5% |
| | 2 | Шат гишгүүрээс ойчих 8.9% | Шат гишгүүрээс ойчих 12.1% | Шат гишгүүрээс ойчих 11.8% |
| | 3 | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.5% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 7.9% | Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 7.5% |
| | 4 | Хүнтэй мөргөлдөн, түлхэгдэн ойчих 4.9% | Орноос унах 4.5% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.8% |
| | 5 | Тоглоом ба спортын талбай 4.8% | Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.7% | Орноос унах 4.4% |



Уналтын шалтгаант шинэ тохиолдол Дорноговь, Дархан-Уул, Төв аймгуудад их, Төвийн бүсэд бусад бүстэй харьцуулахад өндөр байна.

Уналтын шалтгаант шинэ тохиолдол бүртгэгдсэн харьяаллаар




1.2 АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /W20-W49/

2022 онд Амьгүй механик хүчинд өртөж гэмтэх шалтгаант 30386 тохиолдол бүртгэгдсэн ба энэ нь тухайн жилийн нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 16%-ийг эзэлж байна. 2018 оноос 2022 онд 29.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Монгол улсын 10 000 хүн ам тутамд 91 хүн амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн байна.




Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлын 68% эрэгтэй /20771/, 32 эмэгтэй /9615/ байна.


2022 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчллийн тохиолдлын тоо 30-34 насанд /3522 /их байгаа боловч тохиолдлын түвшин 20-24 насанд /141.7/ бусад наснаас их байна.



Тэргүүлэх 5 шалтгаан





Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн нийт тохиолдлын 42.9% бугуй ба сарвууны, 19.1% толгой, 9.5% тохой ба шуу гэмтсэн байна.



Аль ч насанд бусад зүйл мөргөх буюу цохигдох шалтгаан тэргүүлж байна.

| Насны бүлэг | Амьгүй механик хүчинд өртөх | | | | |
|-----------------|---------------------------------------|---|---|--|--|
| | I | II | III | IV | V |
| 0-4 n=2726 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 46.1% | Хоёр юмны хооронд хавчигдах 18.4% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 10.9% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 7.1% | Хурц шилэнд зүсэгдэх 6.4% |
| 5-9 n=2493 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 44.4% | Хоёр юмны хооронд хавчигдах 12.8% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 12.2% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 11.1% | Хурц шилэнд зүсэгдэх 6.5% |
| 10-14 n=2977 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 41.9% | Спортын хэрэгсэл мөргөх буюу цохигдох 19.0% | Хурц шилэнд зүсэгдэх 7.8% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 6.9% | Хоёр юмны хооронд хавчигдах 6.8% |
| 15-19 n=2707 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 36.2% | Спортын хэрэгсэл мөргөх буюу цохигдох 11.9% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 10.9% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 10.9% | Хурц шилэнд зүсэгдэх 7.6% |
| 20-24 n=3152 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 26.0% | Хурц шилэнд зүсэгдэх 14.2% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.4% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 11.6% | Хоёр юмны хооронд хавчигдах 9.8% |
| 25-29 n=2828 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.7% | Хурц шилэнд зүсэгдэх 14.5% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.6% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 12.3% | Хутганд өртөх 9.6% |
| 30-34 n=3522 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.3% | Хурц шилэнд зүсэгдэх 13.4% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.9% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 12.6% | Хутганд өртөх 9.0% |
| 35-39 n=2895 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 21.1% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 13.3% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 12.2% | Хурц шилэнд зүсэгдэх 10.7% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 9.9% |
| 40-44 n=2156 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 20.7% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 13.6% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 11.6% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 11.1% | Хутганд өртөх 9.8% |
| 45-49 n=1710 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 19.8% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 13.6% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.8% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 12.5% | Хутганд өртөх 8.7% |
| 50-54 n=1156 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.1% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 15.0% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 11.7% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 11.6% | Хоёр юмны хооронд хавчигдах 10.2% |
| 55-59 n=935 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.7% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 17.7% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 10.0% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 9.8% | Хутганд өртөх 7.8% |
| 60-64 n=611 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.0% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 18.3% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах-12.7% | Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж 9.9% | Хоёр юмны хооронд хавчигдах 8.6% |
| 65-69 n=276 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 21.0% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 15.2% | Хоёр юмны хооронд хавчигдах 14.8% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 13.7% | Хутганд өртөх 8.7% |
| 70+ n=242 | Бусад зүйл мөргөх буюу цохигдох 29.5% | Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд 15.2% | Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 15.2% | Хоёр юмны хооронд хавчигдах 14.4% | Хурц шилэнд зүсэгдэх 5.7% |


2022 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтсэн тохиолдлыг улирлаар тооцоход хамгийн их нь намар 30.0% бүртгэгдсэн байна. Зун 26.6%, хавар 26.5%, хамгийн бага нь өвөл 17.0% бүртгэгдсэн байна.



Амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтсэн тохиолдол нийслэлд 84.6% /25718/, орон нутагт 15.4% /4668/ байна.


2022 онд орон нутагт бүртгэгдсэн амьгүй механик хүчинд өртөх шалтгаант осол гэмтэл Төвийн бүсд /2014/, Дорноговь аймагт /628/ бусад аймгуудаас өндөр байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл бүртгэгдсэн бүсээр




1.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /V01-V99/

Өнгөрөгч онд 21128 хүн зам тээврийн ослын улмаас гэмтэж, энэ нь 2021 оноос 32.4%-иар өссөн байна. Зам тээврийн осол нь осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны нэг бөгөөд 10 000 хүн тутмын 58.3 нь энэхүү осолд өртсөн үзүүлэлттэй байна.



Зам тээврийн осолд өртөж байгаа тохиолдлын 64.2%-ийг /13574/, 35.8%-ийг /7557/ эрчүүд эзэлж байна.


2022 онд зам тээврийн ослын улмаас эмнэлгийн тусламж авсан иргэдийн дундаж нас 30.3 ба насны бүлгээр судлахад 10-14 болон 30-34 насанд тохиолдлыг тоо хамгийн их байгаа бол тухайн насны 10000 хүн амд ногдох үзүүлэлтээр 20-24 насанд өндөр байна.



ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН 2022



Зам тээврийн осолд өртсөн нийт тохиолдлын 32.9%-ийг жолооч, 28.0%-ийг зорчигч, 23.5%-ийг явган зорчигч эзэлж байгаа бол 15.3% нь морь мал унаж явсан байна.










Тээврийн хэрэгслийн төрлийг гэмтсэн эрхтний байршлаар авч үзвэл дугуйнаас бусад тээврийн хэрэгслийн үед тархины гэмтлээр оношлогдсон тохиолдол хамгийн их хувийг эзэлсэн байна. Тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран гэмтлийн ямар онош тэргүүлж байгааг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Зам тээврийн ослын шинэ тохиолдол онош, тээврийн хэрэгслийн төрлөөр

| Тээврийн хэрэгслийн төрөл | Гэмтлийн онош | | | | |
|---|---------------------------------------|---|--|--|--|
| | I | II | III | IV | V |
| V01-V09 (Явган) 4961 | Тархины гэмтэл 30.6% | Өвдөг ба шилбэний гэмтэл 18.0% | Шагай ба тавхайн гэмтэл 15.1% | Хэвлийн гэмтэл 10.2% | Тохой ба шууны гэмтэл 5.3% |
| V10-V19 (Дугуй) 1164 | Тохой ба шууны гэмтэл 20.5% | Тархины гэмтэл 22.4% | Өвдөг ба шилбэний гэмтэл 14.9% | Бугуй ба сарвууны гэмтэл 9.9% | Мөр ба бугалгын гэмтэл 8.8% |
| V20-V39 (Мотоцикл) 3662 | Тархины гэмтэл 35.3% | Өвдөг ба шилбэний гэмтэл 15.2% | Мөр ба бугалгын гэмтэл 10.2% | Цээжний гэмтэл 9.6% | Тохой ба шууны гэмтэл 6.4% |
| V40-V49 (Суудлын машин) 7297 | Тархины гэмтэл 55.4% | Цээжний гэмтэл 11.7% | Хэвлийн гэмтэл 9.4% | Хүзүүний гэмтэл 5.2% | Мөр ба бугалгын гэмтэл 3.7% |
| V50-V69 (Ачааны машин) 407 | Тархины гэмтэл 39.2% | Хэвлийн гэмтэл 13.4% | Цээжний гэмтэл 12.9% | Өвдөг ба шилбэний гэмтэл 8.9% | Мөр ба бугалгын гэмтэл 6.2% |
| V70-V49 (Нийтийн тээвэр) 315 | Тархины гэмтэл 27.9% | Цээжний гэмтэл 16.5% | Хэвлийн гэмтэл 13.3% | Өвдөг ба шилбэний гэмтэл 10.5% | Тохой ба шууны гэмтэл 7.6% |
| V80-V80.9 (Морь) 3322 | Тархины гэмтэл 25.6% | Мөр ба бугалгын гэмтэл 16.0% | Тохой ба шууны гэмтэл 15.1% | Өвдөг ба шилбэний гэмтэл 10.4% | Цээжний гэмтэл 9.9% |
| Нийт хувь 21128 | Тархины гэмтэл 35.8% | Өвдөг ба шилбэний гэмтэл 10.9% | Цээжний гэмтэл 9.3% | Хэвлийн гэмтэл 8.6% | Мөр ба бугалгын гэмтэл 7.0% |

Явганаар болон унадаг дугуй, автобусаар явж байхдаа зам тээврийн осолд орсон тохиолдлуудад зөөлөн эдийн гэмтэл, суудлын болон ачааны машинтай явж байсан тохиолдлуудад гавал тархины доторх гэмтэл мотоцикл болон морь унаж яваад осолд орсон тохиолдлуудад ясны хугарлын гэмтлүүд зонхилон тохиолдож байна.

Хүснэгт 2. Зам тээврийн ослоор эмнэлэгт хандсан иргэдийн гэмтлийн төрөл, тээврийн хэрэгслийн төрлөөр


| № |  V00-V09 |  V10-V19 |  V20-V39 |  V40-V49 |  V50-V69 |  V70-V79 |  V80 |
|---|---|---|---|---|--|---|---|
| 1 | Зөөлөн эдийн/г 48.3% | Зөөлөн эдийн/г 43.9% | Хугарал 35.0% | Гавал доторх/г 40.0% | Гавал доторх/г 29.0% | Зөөлөн эдийн/г 50.5% | Хугарал 44.3% |
| 2 | Гавал доторх/г 21.7% | Хугарал 24.1% | Зөөлөн эдийн/г 22.5% | Зөөлөн эдийн/г 29.3% | Хугарал 26.8% | Гавал доторх/г 17.5% | Зөөлөн эдийн/г 23.6% |
| 3 | Хугарал 15.1% | Шарх 13.5% | Гавал доторх/г 20.0% | Хугарал 14.9% | Зөөлөн эдийн/г 26.3% | Хугарал 16.8% | Гавал доторх/г 15.5% |
| 4 | Шарх 6.5% | Гавал доторх/г 12.6% | Шарх 11.9% | Шарх 6.4% | Шарх 7.2% | Бусад 5.1% | Шарх 7.1% |
| 5 | Бусад 3.9% | Мултрах, сунах 2.9% | Мултрах, сунах 4.2% | Бусад 3.8% | Бусад 3.7% | Шарх 5.1% | Мултрах, сунах 4.1% |

2022 онд зам тээврийн осолд өртсөн нийт тохиолдлын 7.8% /1641/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байгаа ба тээврийн хэрэгслийн төрлөөр харвал мотоциклтой зорчигчийн согтуу үедээ осолд өртсөн хувь бусад тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад өндөр байна.

Хүснэгт 3. Зам тээврийн осолд өртсөн иргэдийн согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувиар


| Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх | Тээврийн хэрэгслийн төрөл | | | | | | |
|------------------------------------|---------------------------|--------------------|-----------------------|----------------------------|---------------------------|-----------------------------|---------------------|
| | V01-V09 (Явган) | V10-V19 (Дугуй) | V20-V39 (Мотоцикл) | V40-V49 (Суудлын машин) | V50-V69 (Ачааны машин) | V70-V49 (Нийтийн тээвэр) | V80-V80.9 (Морь) |
| | Хувиар | | | | | | |
| Тийм | 9.5 | 0.9 | 16.4 | 5.7 | 8.2 | 0.9 | 3.2 |
| Үгүй | 90.5 | 99.1 | 83.6 | 94.3 | 91.8 | 99.1 | 96.8 |

Суудлын машинтай явж байгаад зам тээврийн осолд өртсөн тохиолдлын 22.8%-д, ачааны машинтай явж байсан тохиолдлын 24.2% нь суудлын хамгаалах бүстэй байсан гэсэн өгүүлэмжтэй байна.




Улирлаас хамаарсан ялгаа ажиглагддаг осол гэмтлийн шалтгааны нэг нь зам тээврийн осол юм. 2022 оны зам тээврийн ослын шалтгаант өвчлөлийн 35.4% нь зуны улиралд тохиолдсон байна.

Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн улирлаар




Зам тээврийн осолд өртсөний улмаас эмнэлэгт хандах тохиолдол 7 сард бусад саруудтай харьцуулахад өндөр байна

Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн сараар



Зам тээврийн осолд өртөж буй гарагаар авч үзвэл даваа болон баасан гарагт бусад өдрүүдээс их байна.



Нийт тохиолдлын 69.7% нь нийслэлд, 30.3% нь орон нутагт бүртгэгдсэн байгаа ба нийслэлд тохиолдлын түвшин орон нутгаас 3 дахин өндөр байхад нас баралтын түвшин орон нутагт нийслэлээс 2 дахин өндөр байна.

Хүснэгт 4. Зам тээврийн осол бүртгэгдсэн харъяаллаар, 10000 хүн амд

| Бүртгэгдсэн газар | Шинэ тохиолдол | | Тохиолдлын түвшин | Нас баралтын түвшин |
|-------------------|----------------|-------|-------------------|---------------------|
| | Бодит тоо | Хувь | | |
| Нийслэл | 14731 | 69.7% | 95.7 | 0.8 |
| Орон нутаг | 6397 | 30.3% | 36.1 | 1.9 |


Суудлын машины осол нийслэл болон улсын дүнгээр тэргүүлж байгаа болон орон нутагт мотоциклтой зорчигчийн осол тэргүүлж байна. Явган явж байгаад зам тээврийн осолд орж гэмтэх тохиолдол нийслэл болон улсад эзлэх хувиар 2-рт байгаа бол орон нутагт 4-р шалтгаан болсон байна. Мөн эрүүл мэндийн салбарт онцлогоор бүртгэгддэг мориноос унаж гэмтэх тохиолдол нийслэл болон орон нутагт 3-рт орж байна.

Хүснэгт 5. Зам тээврийн осол бүртгэгдсэн харъяалал, тээврийн хэрэгслийн төрлөөр

| Тээврийн хэрэгслийн төрөл | Орон нутаг | | Нийслэл | | Улсын дүнгээр | |
|---------------------------|------------|---|---|---|---------------|------|
| | Төрөл | Хувь | Төрөл | Хувь | Төрөл | Хувь |
| Тээврийн хэрэгслийн төрөл | 1 | Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 34.4% | Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 36.8% | Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 34.5% | | |
| | 2 | Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 29.3% | Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 30.9% | Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 23.5% | | |
| | 3 | Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 25.3% | Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 11.6% | Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 17.3% | | |
| | 4 | Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 6.5% | Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 9.9% | Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 15.7% | | |
| | 5 | Ачааны машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 2.2% | Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 7.0% | Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 5.5% | | |

Зам тээврийн осол Архангай, Хөвсгөл аймагт тэргүүлж Хангайн бүсэд хамгийн олон тохиолдсон бүртгэгдсэн байна.

Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн аймаг, бүсээр





II БҮЛЭГ


2022 оны осол гэмтлийн шалгаант нас баралтын байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ 2022

2. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

2022 онд гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт 3353 бүртгэгдсэн нь нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 1.8%-ийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралт өмнөх оноос 0.2%-р өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 10.1 тохиолдол бүртгэгджээ.

**Монгол улсын осол гэмтлийн шалтгаант нас баралт,
10 000 хүн амд**



**Осол гэмтлийн шалтгаант нас баралт,
хүйсээр**



Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 81.2% /2721/ нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин эрэгтэйд 16.7 тохиолдол байна.

84%

Эрэгтэй



2022 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж нас барсан 1913 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүний 1608 /84.0%/ нь эрэгтэйчүүд байна.

2022 онд гэмтэл хордлого, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын дундаж нас 41.7, хамгийн багадаа 12 хоногтой нярай, хамгийн ахмад нь 91 настай байна.

| Дундаж нас | Стандарт хазайлт | Хамгийн бага | Хамгийн их |
|------------|------------------|--------------|------------|
| 41.7 | 16.3 | 0 /12 хоног/ | 91 |

2022 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын 74.7% нь санамсаргүй үйлдэгдсэн осол гэмтэл эзэлж байгаа бол 22.3% нь өөрийнхөө болон бусдын амь насанд санаатайгаар халдсан тохиолдлууд эзэлж байна. Харин нийт нас баралтын 3% нь сэдэл тодорхойгүй нас баралт байна.

САНААТАЙ ОСОЛ ГЭМТЭЛ

/Амиа хорлолт болон хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл/



САНАМСАРГҮЙ ОСОЛ ГЭМТЭЛ


/Уналт, зам тээврийн осол, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, усанд живэлт, түлэгдэлт, хордолт гэх мэт/



Тодорхойгүй 3%

Гэмтэл хордлого гадны шалтгаант нас баралтыг насны бүлэг тус бүрт бодит тоогоор харвал 45-49 насанд 12.9% /433/ хамгийн их тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 50-54 насанд өндөр тохиолджээ.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, насны бүлэг, 10 000 хүн амд




2022 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтыг насны бүлгээр өмнөх онтой харьцуулан судлахад 0-4, 25-29, 35-39, 45-69 насныханд тохиолдлын тоо өссөн үзүүлэлттэй байна. Харин 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 50-54 насанд хамгийн өндөр хэвээр байна.

| Насны бүлэг | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|-------------|-----------|---------------------|-----------|---------------------|-----------|---------------------|
| | Бодит тоо | Нас баралтын түвшин | Бодит тоо | Нас баралтын түвшин | Бодит тоо | Нас баралтын түвшин |
| 0-4 | 150 | 3.9 | 110 | 3.0 | 125 | 3.3 |
| 5-9 | 53 | 1.4 | 55 | 1.4 | 42 | 1.1 |
| 10-14 | 63 | 2.1 | 69 | 2.2 | 60 | 1.9 |
| 15-19 | 90 | 4.1 | 98 | 4.5 | 94 | 4.3 |
| 20-24 | 117 | 4.9 | 165 | 7.3 | 144 | 6.5 |
| 25-29 | 194 | 7.3 | 184 | 7.6 | 213 | 9.0 |
| 30-34 | 264 | 8.5 | 319 | 10.9 | 317 | 10.8 |
| 35-39 | 301 | 11.6 | 357 | 14.1 | 391 | 15.2 |
| 40-44 | 328 | 14.4 | 384 | 17.5 | 380 | 17.1 |
| 45-49 | 325 | 16.0 | 375 | 19.0 | 433 | 21.6 |
| 50-54 | 309 | 18.0 | 346 | 20.5 | 405 | 23.8 |
| 55-59 | 253 | 17.6 | 265 | 18.3 | 326 | 22.0 |
| 60-64 | 136 | 12.8 | 145 | 13.5 | 236 | 21.5 |
| 65-69 | 63 | 10.8 | 75 | 12.1 | 114 | 17.4 |
| 70+ | 90 | 10.5 | 79 | 9.1 | 73 | 8.5 |

Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1-рт санамсаргүй хордох, хорт бодист өртөх **36% /1208/**, 2-рт амиа хорлолт **16.2% /544/**, 3-рт зам тээврийн осол **13.8% /464/**, 4-рт байгалийн хүчинд өртөх **7.6% /256/**, 5-рт уналт **7% /235/** тус тус тэргүүлж байна.

ГЭМТЭЛ, ХОРДЛОГО ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:



Санамсаргүй хордож нас барсан тохиолдол аль ч хүйсэд тэргүүлж байна. Эрэгтэй хүйсэд нас баралтын 2-р шалтгаан амиа хорлох байгаа бол эмэгтэйчүүдийн дунд зам тээврийн осол 2-рт оржээ.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан, хүйсээр




Осол гэмтлийн шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан нь насны бүлэг бүрт харилцан адилгүй байна. 2022 онд 0-4 насанд амьсгал боогдох шалтгаант осол, 5-14 насанд зам тээврийн осол, 15-29 насанд амиа хорлолт, 30-69, 70-с дээш насанд санамаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт тэргүүлж байна.

| Насны бүлэг | Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан-2022 он | | | | |
|-------------------------|---|------------------------------|------------------------------|-----------------------------|----------------------------------|
| | I | II | III | IV | V |
| 0-4 /n=125/ | Амьсгал боогдох 44.8% | Зам тээврийн осол 21.6% | Түлэгдэлт 8.8% | Уналт 8.8% | Усанд живэх 6.4% |
| 5-9 /n=42/ | Зам тээврийн осол 42.9% | Усанд живэх 19.0% | Түлэгдэлт 9.5% | Уналт 7.1% | Амьгүй механик хүчинд өртөх 4.8% |
| 10-14 /n=60/ | Зам тээврийн осол 41.7% | Амиа хорлох 23.3% | Усанд живэх 11.7% | Уналт 10.0% | Хордох 6.7% |
| 15-19 /n=94/ | Амиа хорлох 39.4% | Зам тээврийн осол 16.0% | Уналт 17.0% | Хордох 12.8% | Усанд живэх 6.4% |
| 20-24 /n=144/ | Амиа хорлох 38.9% | Зам тээврийн осол 18.1% | Уналт 11.8% | Хордох 8.3% | Байгалийн хүчинд өртөх 4.9% |
| 25-29 /n=213/ | Амиа хорлох 39.0% | Хордох 17.8% | Зам тээврийн осол 15.5% | Уналт 8.0% | Усанд живэх 6.1% |
| 30-34 /n=317/ | Хордох 26.8% | Амиа хорлох 26.8% | Зам тээврийн осол 16.4% | Хүчирхийлэл 8.8% | Уналт 7.3% |
| 35-39 /n=391/ | Хордох 41.4% | Амиа хорлох 17.4% | Зам тээврийн осол 12.5% | Байгалийн хүчинд өртөх 6.1% | Уналт 6.1% |
| 40-44 /n=380/ | Хордох 46.8% | Амиа хорлох 15.3% | Зам тээврийн осол 10.3% | Байгалийн хүчинд өртөх 7.6% | Хүчирхийлэл 6.0% |
| 45-49 /n=433/ | Хордох 51.3% | Амиа хорлох 10.6% | Зам тээврийн осол 9.5% | Хүчирхийлэл 7.8% | Байгалийн хүчинд өртөх 7.4% |
| 50-54 /n=405/ | Хордох 46.2% | Байгалийн хүчинд өртөх 12.6% | Зам тээврийн осол 12.3% | Амиа хорлох 8.6% | Хүчирхийлэл 6.7% |
| 55-59 /n=326/ | Хордох 42.3% | Байгалийн хүчинд өртөх 12.9% | Зам тээврийн осол 12.6% | Амиа хорлох 8.9% | Хүчирхийлэл 7.1% |
| 60-64 /n=236/ | Хордох 42.8% | Байгалийн хүчинд өртөх 13.1% | Зам тээврийн осол 10.2% | Амиа хорлох 7.2% | Уналт 7.2% |
| 65-69 /n=114/ | Хордох 36.8% | Уналт 14.9% | Байгалийн хүчинд өртөх 14.0% | Зам тээврийн осол 10.5% | Хүчирхийлэл 7.0% |
| 70+ /n=73/ | Хордох 28.8% | Зам тээврийн осол 16.4% | Уналт 16.4% | Амиа хорлох 11.0% | Байгалийн хүчинд өртөх 9.6% |

Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт 2021 онд 29.9%-р намрын улиралд хамгийн их бүртгэгдэж байсан бол 2022 онд 26.9%-р зуны улиралд хамгийн их тохиолдсон байна.

Нас баралт бүртгэгдсэн улирал, хувиар




Санамсаргүй хордож нас барсан тохиолдол улирал бүрт тэргүүлэх шалтгаан болж байгаа хэдий ч зуны улиралд зам тээврийн осол 2-рт орж, өвөл, хавар, намрын улиралд амиа хорлож нас барсан тохиолдол өндөр байна.

| Бүртгэгдсэн улирал | Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан | | | | |
|--------------------|------------------------------------|----------------------------|---------------------------------|--------------------------------|----------------------|
| | I | II | III | IV | V |
| Өвөл | Хордох 41.7% | Амиа хорлох 14.6% | Байгалийн хүчинд өртөх 13.6% | Зам тээврийн осол 8.6% | Хүчирхийлэл 6.8% |
| Хавар | Хордох 37.1% | Амиа хорлох 16.5% | Зам тээврийн осол 16.0% | Уналт 7.8% | Хүчирхийлэл 6.2% |
| Зун | Хордох 34.3% | Зам тээврийн осол 16.2% | Амиа хорлох 15.6% | Уналт 7.5% | Усанд живэлт 7.3% |
| Намар | Хордох 30.9% | Амиа хорлох 18.4% | Зам тээврийн осол 14.5% | Байгалийн хүчинд өртөх 9.7% | Уналт 6.9% |


Нийт осол гэмтлийн шалтгаант нас баралтыг сараар харвал 12 дугаар сард **10.9%** /365/ хамгийн их бүртгэгдсэн байна.

Нас баралт бүртгэгдсэн сар, хувиар




2021 онд осол гэмтлийн шалтгаант нас баралт даваа гаригт 15.8% /479/ хамгийн өндөр бүртгэгдэж байсан бол 2022 онд бямба гаригт 21.1% /706/-р хамгийн их бүртгэгджээ.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, бүртгэгдсэн гаригаар



Тухайн тайлангийн жилд бүртгэгдсэн 1000 шинэ гэмтэл тутамд ногдох үхлийн түвшин усанд живж нас барах, амьсгал боогдох, санамсаргүй хордох, амиа хорлох, байгалийн хүчинд өртөх зэрэг шалтгаанууд /256.3-821.4 тохиолдол/ тэргүүлж байна. Энэ нь усанд живсэн 1000 шинэ гэмтэл тутамд 821.4 тохиолдол нь нас баралтаар төгссөн байгааг харуулж байна.

1000 шинэ гэмтэл тутамд ногдох нас баралт, шалтгаанаар




2021 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн шалтгаант нас баралтын 62% /2078/ нь нийслэлд, 38% /1275/ нь орон нутагт бүртгэгдсэн байна. 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин нийслэлд өмнөх оноос 1.5 тохиолдлоор, орон нутагт 0.5 тохиолдлоор өссөн байна. Харин 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшин 2021 онд нийслэлд 13.5, орон нутагт 45.9 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2022 онд үхлийн түвшин буурсан үзүүлэлттэй байна.

| Бүртгэгдсэн газар | Нас баралт | | Нас баралтын түвшин | Үхлийн түвшин |
|-------------------|------------|--------|---------------------|---------------|
| | Бодит тоо | Хувиар | | |
| Нийслэл | 2078 | 62% | 13.5 | 12.9 |
| Орон нутаг | 1275 | 38% | 7.2 | 45.9 |


Орон нутагт осол гэмтлийн шалтгаант нас баралт 1275 бүртгэгдсэн ба үүнээс Хөвсгөл болон Төв аймагт хамгийн их тохиолдол бүртгэгдэж, Говьсүмбэр аймагт 19 хамгийн бага тохиолдол бүртгэгдсэн байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, харьяаллаар



Нас баралт бүртгэгдсэн байршлыг бүсээр харвал Хангайн бүсэд хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, бүсээр




Нас баралтын тэргүүлэх шалтгааныг бүртгэгдсэн газраар харвал Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймагт санамсаргүй хордож нас барсан шалтгаан тэргүүлж байгаа бөгөөд Дорнод, Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл аймагт амиа хорлох шалтгаан тэргүүлж байна. Харин бусад аймгуудад зам тээврийн ослын шалтгаан 1-рт оржээ. Нас баралтын тэргүүлэх шалтгаан тус бүрийг дараах хүснэгтээс харна уу.


| Харьяалал | Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан | | | | |
|-------------|-----------------------------------|------------------------------|-----------------------------------|----------------------------------|----------------------------------|
| | I | II | III | IV | V |
| Архангай | Зам тээврийн осол 39.6% | Хордох 14.3% | Амиа хорлох 13.2% | Амьсгал боогдох 8.8% | Байгалийн хүчинд өртөх 6.6% |
| Баян-Өлгий | Зам тээврийн осол 23.3% | Усанд живэх 18.6% | Амьсгал боогдох 13.9% | Амиа хорлох 11.6% | Байгалийн хүчинд өртөх 9.3% |
| Баянхонгор | Зам тээврийн осол 34.8% | Амиа хорлох 27.3% | Хордох 13.6% | Амьсгал боогдох 7.6% | Байгалийн хүчинд өртөх 6.1% |
| Булган | Зам тээврийн осол 27.9% | Амиа хорлох 25.6% | Хордох 13.9% | Түлэгдэлт 7.0% | Уналт 7.0% |
| Говь-Алтай | Зам тээврийн осол 38.5% | Амиа хорлох 30.8% | Хордох 12.8% | Усанд живэх 7.7% | Амьсгал боогдох 2.6% |
| Говьсүмбэр | Хордох 36.8% | Амьсгал боогдох 15.8% | Амьгүй механик хүчинд өртөх 15.8% | Зам тээврийн осол 10.5% | Хүчирхийлэл 5.3% |
| Дархан-Уул | Хордох 25.6% | Зам тээврийн осол 13.9% | Амиа хорлох 13.9% | Уналт 13.9% | Амьсгал боогдох 9.3% |
| Дорнод | Амиа хорлох 24.5% | Зам тээврийн осол 20.4% | Уналт 18.4% | Хордох 10.2% | Хүчирхийлэл 8.2% |
| Дорноговь | Зам тээврийн осол 23.6% | Хордох 23.6% | Амиа хорлох 22.2% | Амьсгал боогдох 8.3% | Байгалийн хүчинд өртөх 5.6% |
| Дундговь | Зам тээврийн осол 41.7% | Амиа хорлох 22.2% | Хордох 11.1% | Хүчирхийлэл 8.3% | Түлэгдэлт 8.3% |
| Завхан | Зам тээврийн осол 35.6% | Амиа хорлох 20.0% | Хордох 11.1% | Байгалийн хүчинд өртөх 11.1% | Амьсгал боогдох 6.7% |
| Орхон | Хордох 43.9% | Амиа хорлох 19.4% | Уналт 8.2% | Хүчирхийлэл 8.2% | Байгалийн хүчинд өртөх 7.1% |
| Өвөрхангай | Зам тээврийн осол 32.8% | Хордох 20.3% | Амиа хорлох 17.2% | Байгалийн хүчинд өртөх 9.4% | Амьсгал боогдох 9.4% |
| Өмнөговь | Амиа хорлох 47.2% | Зам тээврийн осол 30.2% | Хордох 15.1% | Хүчирхийлэл 1.9% | Уналт 1.9% |
| Сүхбаатар | Зам тээврийн осол 38.9% | Байгалийн хүчинд өртөх 25.0% | Амиа хорлох 13.9% | Амьсгал боогдох 11.1% | Хордох 5.6% |
| Сэлэнгэ | Зам тээврийн осол 26.2% | Хордох 17.5% | Амиа хорлох 17.5% | Амьсгал боогдох 12.5% | Байгалийн хүчинд өртөх 7.5% |
| Төв | Зам тээврийн осол 29.9% | Хордох 23.9% | Амиа хорлох 12.0% | Байгалийн хүчинд өртөх 7.7% | Амьсгал боогдох 6.8% |
| Увс | Зам тээврийн осол 31.1% | Амиа хорлох 31.1% | Хордох 16.4% | Усанд живэх 8.2% | Амьсгал боогдох 4.9% |
| Ховд | Зам тээврийн осол 44.7% | Амиа хорлох 18.4% | Уналт 10.5% | Амьгүй механик хүчинд өртөх 7.9% | Байгалийн хүчинд өртөх 5.3% |
| Хэнтий | Амиа хорлох 28.1% | Зам тээврийн осол 21.0% | Хордох 15.8% | Хүчирхийлэл 8.8% | Амьгүй механик хүчинд өртөх 8.8% |
| Хөвсгөл | Амиа хорлох 29.6% | Хордох 18.4% | Зам тээврийн осол 16.8% | Усанд живэх 12.0% | Байгалийн хүчинд өртөх 7.2% |
| Улаанбаатар | Хордох 46.8% | Амиа хорлох 12.8% | Уналт 8.5% | Байгалийн хүчинд өртөх 8.2% | Хүчирхийлэл 7.3% |

2.1 САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТӨХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х40-Х49/

2022 онд улсын хэмжээнд санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт 1208 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 18.7%-р өссөн байна. Мөн 10 000 хүн ам тутмын 3.6 тохиолдол нь санамсаргүй хордож нас барсан бөгөөд энэхүү үзүүлэлт нь өмнөх онтой харьцуулахад 0.6 тохиолдлоор нэмэгдсэн байна.



Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, хүйсээр



Хордож нас барсан тохиолдлын 80%-ийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд 10 000 хүн тутамд ногдох нас баралтын түвшин 5.9 тохиолдол байна.


Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, эзлэх хувь



Санамсаргүй хордсон шалтгаант нас баралт



Бусад гэмтэл, хордлого, гадны шалтгааны нас баралт




0% 20% 40% 60% 80%

2022 онд нийт гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтын 36.0%-ийг санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаан эзэлж байгаа бөгөөд осол гэмтлийн улмаас нас барсан 3 хүн тутмын 1 нь хордолтын шалтгаантай байна.

Санамсаргүй хордсон нас баралт 45-49 насанд тохиолдлын тоо болон 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин хамгийн өндөр байна. Харин бусад насны бүлэгт санамсаргүй хордох, хорт бодист өртсөн тохиолдол харилцан адилгүй бүртгэгдсэн байна.






Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, насны бүлгээр



Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын **98.5%** нь эмийн бус бодист хордсон байна.



Санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барсан тохиолдлын тэргүүлэх шалтгааныг авч үзвэл **спиртэнд санамсаргүй хордсон тохиолдол дангаараа 88.3%**-ийг эзэлж байна.

-  **X45** Спиртэнд санамсаргүй хордох 88.3%
-  **X47** Бусад хий, ууранд санамсаргүй хордох, өртөх 8.8%
-  **X49** Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох, өртөх 1.3%
-  **X42** Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох, өртөх 0.5%
-  **X44** Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох өртөх 0.4%

Санамсаргүй хордож нас барсан шалтгаан тус бүрийг насны бүлгээр харвал 20-24 насанд Эм, биологийн бэлдмэлд хордох 22.2%, 45-49 насанд Спиртэнд санамсаргүй хордох 19.8%, 40-44 насанд Бусад хий, ууранд санамсаргүй хордох 16%, 15-19 насанд Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох шалтгаанууд тэргүүлсэн байна.

| Насны бүлэг | Эм, биологийн бэлдмэлийн хордлого /X40-X44/ | | Спиртэнд санамсаргүй хордох /X45/ | | Бусад хий, ууранд санамсаргүй хордох /X47/ (угаарын хийн хордлого, ахуйн газ г.м) | | Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох /X49/ | |
|-------------|---|------------|-----------------------------------|------------|---|------------|---|------------|
| | Нас баралт | Хувь | Нас баралт | Хувь | Нас баралт | Хувь | Нас баралт | Хувь |
| 0-4 | 2 | 11.1 | | | 1 | 0.9 | 3 | 17.6 |
| 10-14 | | | | | 3 | 2.8 | 1 | 5.9 |
| 15-19 | | | 1 | 0.1 | 7 | 6.6 | 4 | 23.5 |
| 20-24 | 4 | 22.2 | 4 | 0.4 | 4 | 3.8 | | |
| 25-29 | 3 | 16.7 | 26 | 2.4 | 8 | 7.5 | 1 | 5.9 |
| 30-34 | 3 | 16.7 | 76 | 7.1 | 6 | 5.7 | | |
| 35-39 | 1 | 5.6 | 154 | 14.4 | 5 | 4.7 | 2 | 11.8 |
| 40-44 | | | 160 | 15.0 | 17 | 16.0 | 1 | 5.9 |
| 45-49 | | | 211 | 19.8 | 9 | 8.5 | 2 | 11.8 |
| 50-54 | | | 170 | 15.9 | 14 | 13.2 | 3 | 17.6 |
| 55-59 | 1 | 5.6 | 126 | 11.8 | 11 | 10.4 | | |
| 60-64 | 1 | 5.6 | 90 | 8.4 | 10 | 9.4 | | |
| 65-69 | | | 36 | 3.4 | 6 | 5.7 | | |
| 70+ | 3 | 16.7 | 13 | 1.2 | 5 | 4.7 | | |
| Нийт | 18 | 100 | 1067 | 100 | 106 | 100 | 17 | 100 |

2022 онд X47-Бусад хий ууранд санамсаргүй хордох /угаарын хийн хордлого, ахуйн газанд хордох г.м/ шалтгаант нас баралт өмнөх оноос 28.4%-р буурсан байна. Харин X45-Спиртэнд санамсаргүй хордож нас барсан тохиолдол өмнөх оноос 24.5%-р өссөн ба бусад шалтгаанууд мөн харилцан адилгүй өссөн үзүүлэлттэй байна.

| Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанууд /X40-X49/ | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|--|------|------|------|------|------|
| X40 Опиоид бус өвчин намдаах, халуун бууруулах ба хэрлэгийн эсрэг эмэнд санамсаргүй хордох | 1 | 1 | 0 | 0 | 4 |
| X41 Өөр бүлэгт ангилаагүй таталтын эсрэг, тайвшруулах, паркинсоны өвчний эсрэг, сэтгэц нөлөөт эмэнд санамсаргүй хордох | 0 | 0 | 0 | 0 | 2 |
| X42 Өөр бүлэгт ангилаагүй хар тамхины ба психодислептик эмэнд санамсаргүй хордох | | | | | 6 |
| X43 Тусгаар мэдрэлийн тогтолцоонд нөлөөлдөг бусад эмэнд санамсаргүй хордох | | | | | 1 |
| X44 Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох | 2 | 6 | 2 | 4 | 5 |
| X45 Спиртэнд санамсаргүй хордох | 726 | 668 | 651 | 857 | 1067 |
| X46 Органик уусгагч, халоген агуулсан нүүрсустөрөгч, тэдгээрийн уураар санамсаргүй хордох | 2 | 4 | 0 | 1 | 1 |
| X47 Бусад хий, ууранд санамсаргүй хордох /угаарын хийн хордлого, газ г.м/ | 76 | 50 | 107 | 148 | 106 |
| X48 Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох | 0 | 1 | 1 | 1 | 0 |
| X49 Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох | 18 | 18 | 13 | 7 | 16 |



Санамсаргүй хордох нас баралт 2021 онд намрын улиралд хамгийн их тохиолдож байсан бол 2022 онд өвөл хамгийн өндөр бүртгэгджээ. Хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бүгд өвөл нас барах тохиолдол их байна.

Хордож нас барсан тохиолдол, хүйс, улирлаар



2021 онд санамсаргүй хордож нас барсан тохиолдол 10, 11 сард хамгийн өндөр байсан бол 2022 онд 2, 12 сард хамгийн их бүртгэгджээ.

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, сараар



2022 онд нийслэл хотод 972 хүн хордолтын улмаас нас барсан нь өмнөх онтой харьцуулахад 20.7%-р өссөн байна. Харин хөдөө орон нутагт 236 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 10.8%-р өссөн үзүүлэлттэй байна.

Жилд нийслэлийн 10 000 хүн тутмын 6 нь, орон нутгийн 10 000 хүн тутмын 1 нь санамсаргүй хордож нас барсан байна. Мөн 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшин нийслэлд хотод 419.5, орон нутагт 298 тохиолдол байна.


| Бүртгэгдсэн газар | Шинэ тохиолдол | Нас баралт | Хувь | Үхлийн түвшин | Нас баралтын түвшин |
|-------------------|----------------|------------|-------|---------------|---------------------|
| Нийслэл | 2317 | 972 | 80.5% | 419.5 | 6.3 |
| Орон нутаг | 792 | 236 | 19.5% | 298.0 | 1.3 |

Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралтын 1067 /88.3%/г **X45-** Спиртэнд хордох шалтгаан эзэлдэг ба 2022 оны байдлаар Монгол улс сард дунджаар 88.9, өдөрт дунджаар 2-3 хүнээ архины улмаас алдсан байна.




Санамсаргүй хордож нас барсан тохиолдлыг бүртгэгдсэн газраар харвал Орхон аймагт хамгийн их, Ховд аймагт хамгийн бага тохиолдол бүртгэгджээ. Бүсээр авч үзэхэд Хангайн бүсэд тохиолдлын тоо өндөр байна.

Санамсаргүй хордох шалтгаант нас баралт, харьяаллаар



2.2 САНААТАЙГААР ӨӨРТӨӨ ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х60-Х84/


Монгол улсад 2018-2022 онд амиа хорлож нас барсан нийт 2368 тохиолдол бүртгэгдсэн байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 2022 онд/544/ хамгийн өндөр тохиолдол бүртгэгджээ. 2019 оноос хойш санаатайгаар өөртөө гэмтэл учруулж нас барсан тохиолдол нэмэгдсээр байгаа бөгөөд 2022 онд өмнөх оноос 12.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн нас баралтын түвшин 2022 оныг 2018 онтой харьцуулахад 0.2 тохиолдлоор өссөн байна.



2022 онд амиа хорлож нас барсан 10 хүн тутмын 8 нь эрэгтэй байна.




2018-2022 онд санаатайгаар өөртөө гэмтэл учруулж нас барсан 2037 эрэгтэй, 341 эмэгтэй бүртгэгдсэн байна. Тухайн шалтгаанаар нас барсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 6 дахин их бүртгэгджээ. Нас баралтын түвшин эрэгтэйд эмэгтэйгээс 2-2.4 тохиолдлоор их байна. Амиа хорлож нас барах тохиолдол эрэгтэйчүүдийн дунд ихсэх хандлага ажиглагдаж байна.




Амиа хорлох оролдлого хийсэн 1000 хүн тутмын 379-421 нь нас баралтаар төгссөн байна. Үхлийн түвшин 2020 онд/421/ хамгийн өндөр байжээ.

Амиа хорлох шалтгаант нас баралт 10000 хүн амд, 1000 амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд, оноор




Нас баралтын тоо 30-34 насанд/85/, Нас баралтын түвшин 25-29 насанд/3.5/, Үхлийн түвшин 5-9 насанд/1000/ бусад наснаас өндөр байна. Өөрөөр хэлбэл 25-29 насны 10000 хүн тутамд 3 нь амиа хорлож нас барсан байна.

Амиа хорлох шалтгаант нас баралт насны бүлэг, 10000 хүн амд, 1000 гэмтэл тутам



2022 онд хамгийн бага нас 8, хамгийн өндөр настай 88, эрэгтэй амиа хорлож нас барсан байна.


Амиа хорлох шалтгаант нас баралт насны бүлэг, хүйс, бодит тоогоор



Тэргүүлэх 5 шалтгаан:


| | | | |
|----|-----|--|-------|
| 1. | X70 | Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох | 91.7% |
| 2. | X73 | Өөрийгөө санаатай буудах | 3% |
| 3. | X78 | Өөрийгөө иртэй зүйлээр санаатай гэмтээх | 2.2% |
| 4. | X80 | Санаатайгаар өөрөө өндрөөс үсрэх | 1.7% |
| 5. | X65 | Спирт, бусад бодисоор өөрийгөө санаатай хордуулах | 0.8% |

2022 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдол улиралын хувьд харилцан ялгаагүй байна. Тухайн шалтгааны нас баралт орон нутагт өндөр байна.



Орон нутагт Хөвсгөл аймагт бусад аймгуудаас, Хангайн бүс бусад бүсээс амиа хорлож нас барсан тохиолдол өндөр байна.

Амиа хорлож нас барсан бодит тоо, бүртгэгдсэн аймаг, бүсээр




2.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /V01-V99/

2022 онд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 464 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 0.9%-р буурсан үзүүлэлттэй байна. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт нь нийт нас баралтын 13.8%-ийг эзэлдэг бөгөөд нас баралтын тэргүүлэх шалтгааны 3-рт орсон байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10 000 хүн амд



Зам тээврийн ослоор амь насаа алдсан нийт тохиолдлын 78% нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд 10 000 эрэгтэй тутамд ногдох нас баралтын түвшин 2.2 тохиолдол байна.



10 000 хүн амд

Эрэгтэй **2.2**
Эмэгтэй **0.6**



Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж нас барсан тохиолдлын тоо болон өсөлтийн хувь өмнөх онуудаас буурсан байна. Гэсэн хэдий ч 2022 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 31.2% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ нас барсан байна.

Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг насны бүлгээр харвал 30-34 насанд хамгийн их тохиолдол бүртгэгдэж, 50-54 насанд 10 000 хүн амд ногдох нас баралт 2.9 тохиолдлоор хамгийн өндөр байна.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт насны бүлгээр,
10 000 хүн амд**



Зам тээврийн ослын шалтгаант нас баралт 2021 онд 33.7%-р намрын улиралд хамгийн их бүртгэгдэж байсан бол 2022 онд 31.5%-р зуны улиралд хамгийн их тохиолдол бүртгэгджээ. Улирал бүрт суудлын машинтай явж байх үедээ осолд орж нас барах тохиолдол тэргүүлж байна. Харин өвөл 27.8%, хавар 23.7% нь явган явж байх үедээ осолд орж нас барсан тохиолдол, намар 30.4%, зун 23.3% нь мотоциклтой явж байх үедээ осолд орж нас барсан тохиолдол тэргүүлэх шалтгааны 2-рт орж байна.


| Нас баралт бүртгэгдсэн улирлаар | Суудлын машинтай явж байх үед | Мотоциклтой явж байх үед | Явган явж байх үед | Ердийн хөсөг, мал амьтан унаж явах үед | Ачааны машинтай явж байх үед |
|---------------------------------|-------------------------------|--------------------------|--------------------|--|------------------------------|
| Өвөл 72 /15.5%/ | 37.5% | 22.2% | 27.8% | 6.9% | 5.6% |
| Хавар 131 /28.2%/ | 42.7% | 20.6% | 23.7% | 9.9% | 2.3% |
| Зун 146 /31.5%/ | 35.6% | 23.3% | 19.2% | 16.4% | 2.7% |
| Намар 115 /24.8%/ | 37.4% | 30.4% | 25.2% | 4.3% | 0.9% |

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан тохиолдлыг насны бүлэг, тээврийн хэрэгслийн төрлөөр /тэргүүлэх шалтгаан/ харьцуулан судлахад 0-4, 15-24, 30-44, 55-с дээш насанд суудлын машинтай явж байгаад зам тээврийн осолд орж нас барсан тохиолдол, 5-14, насанд ердийн хөсөг буюу морь, мал унаж яваад нас барсан тохиолдол, 25-29, 45-49 насанд мотоциклтой явж байгаад осолд орж нас барсан тохиолдол, 50-54 насанд явган явж байгаад зам тээврийн ослоор нас барсан тохиолдол тус тус тэргүүлж байна.

| Насны бүлэг | Тэргүүлэх 5 шалтгаан | | | | |
|-------------|-------------------------------------|-------------------------------------|------------------------------------|------------------------------------|--|
| | I | II | III | IV | V |
| 0-4 | Суудлын машинтай явж байх үед 63.0% | Явган явж байх үедээ 37% | | | |
| 5-9 | Ердийн хөсөг унаж явах үедээ 61.1% | Суудлын машинтай явж байх үед 16.7% | Явган явж байх үедээ 11.1% | Дугуйтай явж байх үед 5.6% | Мотоциклтой явж байх үед 5.6% |
| 10-14 | Ердийн хөсөг унаж явах үедээ 48.0% | Суудлын машинтай явж байх үед 32.0% | Явган явж байх үедээ 12.0% | Мотоциклтой явж байх үед 4.0% | Ачааны машинтай явж байх үед 5.6% |
| 15-19 | Суудлын машинтай явж байх үед 53.3% | Мотоциклтой явж байх үед 20.0% | Ачааны машинтай явж байх үед 13.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 6.7% | Явган явж байх үедээ 6.7% |
| 20-24 | Суудлын машинтай явж байх үед 53.8% | Мотоциклтой явж байх үед 23.1% | Явган явж байх үедээ 11.5% | Ердийн хөсөг унаж явах үедээ 7.7% | Ачааны машинтай явж байх үед 3.8% |
| 25-29 | Мотоциклтой явж байх үед 48.5% | Суудлын машинтай явж байх үед 33.3% | Явган явж байх үедээ 15.1% | Ачааны машинтай явж байх үед 3.0% | |
| 30-34 | Суудлын машинтай явж байх үед 44.2% | Мотоциклтой явж байх үед 32.7% | Явган явж байх үедээ 23.1% | | |
| 35-39 | Суудлын машинтай явж байх үед 34.7% | Мотоциклтой явж байх үед 24.5% | Явган явж байх үедээ 24.5% | Ердийн хөсөг унаж явах үедээ 10.2% | Ачааны машинтай явж байх үед 4.1% |
| 40-44 | Суудлын машинтай явж байх үед 38.5% | Явган явж байх үедээ 30.8% | Мотоциклтой явж байх үед 17.9% | Ердийн хөсөг унаж явах үедээ 12.8% | |
| 45-49 | Мотоциклтой явж байх үед 36.6% | Суудлын машинтай явж байх үед 21.9% | Явган явж байх үедээ 21.9% | Ердийн хөсөг унаж явах үедээ 12.2% | Хөдөө аж ахуйн хэрэгсэлтэй явж байх үед 4.9% |
| 50-54 | Явган явж байх үедээ 30.0% | Суудлын машинтай явж байх үед 30.0% | Мотоциклтой явж байх үед 26.0% | Ачааны машинтай явж байх үед 6.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 6.0% |
| 55-59 | Суудлын машинтай явж байх үед 31.7% | Мотоциклтой явж байх үед 29.3% | Явган явж байх үедээ 29.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 4.9% | Ачааны машинтай явж байх үед 2.4% |
| 60-64 | Суудлын машинтай явж байх үед 45.8% | Мотоциклтой явж байх үед 20.8% | Явган явж байх үедээ 25.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 4.2% | Хөдөө аж ахуйн хэрэгсэлтэй явж байх үед 4.2% |
| 65-69 | Суудлын машинтай явж байх үед 50.0% | Мотоциклтой явж байх үед 25.0% | Явган явж байх үедээ 25.0% | | |
| 70+ | Суудлын машинтай явж байх үед 66.7% | Явган явж байх үедээ 25.0% | Мотоциклтой явж байх үед 8.3% | | |

Сараар авч үзвэл 2021 онд 10 сард хамгийн их тохиолдол бүртгэгдэж байсан бол 2022 онд 7 сард хамгийн их хувь нь нас барсан байна. Хүйсээр харвал зам тээврийн ослын шалтгаант нас баралт нь эрэгтэй хүйсэд 6,7,9 сард, эмэгтэй хүйсэд 7 сард тохиолдлын тоо өндөр байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, гэмтсэн сараар



2022 оны байдлаар суудлын машинтай зорчих үедээ зам тээврийн осолд өртсөн тохиолдол 178 /38.4%/, мотоциклтой зорчиж байгаад амь насаа алдсан тохиолдол 112 /24.1%/, явган зорчигч тээврийн хэрэгсэлд мөргүүлж нас барсан тохиолдол 108 /23.3%/-ийг эзэлж тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН /2022/



Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл нийслэлд өндөр бүртгэгдэж байсан бол нас баралтын дийлэнх тохиолдол нь 343 /73.9%/ орон нутагт бүртгэгдэж байгаа нь анхаарал татахуйц байна. Мөн 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшин орон нутагт 53.6 тохиолдол байна.



2022 онд зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг тархины гэмтэл 301 /64.9%/-р тэргүүлж байгаа бөгөөд энэхүү тэргүүлж буй 5 онош нь нийт тохиолдлыг 95.7%-ийг эзэлж байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ, ГЭМТЛИЙН БАЙРШЛААР



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгааныг бүртгэгдсэн харьяаллаар харвал Архангай, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад мотоциклтой явж байх үедээ осолд орж нас барсан тохиолдол тэргүүлж байгаа бол Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дархан, Дорноговь, Завхан, Орхон, Төв, Увс, Сэлэнгэ, Ховд, Хэнтий аймагт суудлын машинтай явж байх үедээ осолд орж нас барсан тохиолдол, Дорнод аймагт ердийн хөсөг мал амьтантай явж байх үедээ унаж нас барсан тохиолдол тэргүүлсэн байна. Харин нийслэл хотод явган явж байх үедээ зам тээврийн осолд орж нас барсан тохиолдол хамгийн их бүртгэгджээ.

| Харьяалал | Тэргүүлэх 5 шалтгаан | | | | |
|------------|-------------------------------------|-------------------------------------|------------------------------------|------------------------------------|-----------------------------------|
| | I | II | III | IV | V |
| Архангай | Мотоциклтой явж байх үед 36.1% | Суудлын машинтай явж байх үед 25.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 16.7% | Явган явж байх үедээ 13.9% | Ачааны машинтай явж байх үед 2.8% |
| Баян-Өлгий | Суудлын машинтай явж байх үед 30.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 30.0% | Ачааны машинтай явж байх үед 20.0% | Явган явж байх үедээ 10.0% | Мотоциклтой явж байх үед 10.0% |
| Баянхонгор | Суудлын машинтай явж байх үед 47.8% | Мотоциклтой явж байх үед 34.8% | Явган явж байх үедээ 8.7% | Автобустай явж байх үед 4.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 4.3% |
| Булган | Мотоциклтой явж байх үед 50.0% | Суудлын машинтай явж байх үед 33.3% | Явган явж байх үедээ 8.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 8.3% | |
| Говь-Алтай | Мотоциклтой явж байх үед 40.0% | Суудлын машинтай явж байх үед 20.0% | Явган явж байх үедээ 20.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 13.3% | Ачааны машинтай явж байх үед 6.7% |
| Говьсүмбэр | Суудлын машинтай явж байх үед 50.0% | Явган явж байх үедээ 50.0% | | | |
| Дархан-Уул | Суудлын машинтай явж байх үед 50.0% | Явган явж байх үедээ 50.0% | | | |
| Дорнод | Ердийн хөсөг унаж явах үедээ 40.0% | Суудлын машинтай явж байх үед 30.0% | Мотоциклтой явж байх үед 20.0% | Явган явж байх үедээ 10.0% | |
| Дорноговь | Суудлын машинтай явж байх үед 47.1% | Мотоциклтой явж байх үед 35.3% | Ачааны машинтай явж байх үед 11.8% | Явган явж байх үедээ 5.9% | |
| Дундговь | Мотоциклтой явж байх үед 46.7% | Суудлын машинтай явж байх үед 33.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 13.3% | Явган явж байх үедээ 6.7% | |
| Завхан | Суудлын машинтай явж байх үед 31.2% | Мотоциклтой явж байх үед 25.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 25.0% | Явган явж байх үедээ 12.5% | Ачааны машинтай явж байх үед 6.2% |
| Орхон | Суудлын машинтай явж байх үед 80.0% | Явган явж байх үедээ 20.0% | | | |
| Өвөрхангай | Мотоциклтой явж байх үед 38.1% | Суудлын машинтай явж байх үед 33.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 23.8% | Явган явж байх үедээ 4.8% | |
| Өмнөговь | Мотоциклтой явж байх үед 43.8% | Суудлын машинтай явж байх үед 43.7% | Явган явж байх үедээ 12.5% | | |
| Сүхбаатар | Мотоциклтой явж байх үед 50.0% | Суудлын машинтай явж байх үед 35.7% | Ердийн хөсөг унаж явах үедээ 14.3% | | |
| Сэлэнгэ | Суудлын машинтай явж байх үед 52.4% | Ердийн хөсөг унаж явах үедээ 19.0% | Мотоциклтой явж байх үед 14.3% | Явган явж байх үедээ 9.5% | Ачааны машинтай явж байх үед 4.8% |
| Төв | Суудлын машинтай явж байх үед 62.9% | Мотоциклтой явж байх үед 17.1% | Явган явж байх үедээ 14.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 5.7% | |

| | | | | | |
|-------------|-------------------------------------|-------------------------------------|------------------------------------|------------------------------------|---|
| Увс | Суудлын машинтай явж байх үед 36.8% | Мотоциклтой явж байх үед 26.3% | Явган явж байх үедээ 21.0% | Ердийн хөсөг унаж явах үедээ 15.8% | |
| Ховд | Суудлын машинтай явж байх үед 35.3% | Явган явж байх үедээ 35.3% | Мотоциклтой явж байх үед 23.5% | Ачааны машинтай явж байх үед 5.9% | |
| Хэнтий | Суудлын машинтай явж байх үед 33.3% | Мотоциклтой явж байх үед 33.3% | Ердийн хөсөг унаж явах үедээ 25.0% | Явган явж байх үедээ 8.3% | |
| Хөвсгөл | Мотоциклтой явж байх үед 38.1% | Суудлын машинтай явж байх үед 19.0% | Явган явж байх үедээ 19.0% | Ачааны машинтай явж байх үед 9.5% | Хөдөө аж ахуйн тээврийн хэрэгсэлтэй явж байх үед 9.5% |
| Улаанбаатар | Явган явж байх үедээ 50.4% | Суудлын машинтай явж байх үед 38.0% | Мотоциклтой явж байх үед 5.8% | Ердийн хөсөг унаж явах үедээ 3.3% | Дугуйтай явж байх үед 0.8% |

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт тохиолдлын тоогоор Архангай /36/, Төв аймагт /35/ хамгийн их бүртгэгдсэн бол бүсээр Хангайн бүсэд өндөр байна. Харин Говьсүмбэр аймагт нас баралт бага бүртгэгджээ.

